



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 440

Улаанбаатар хот

Хөрөнгө акталж сэлбэгээр худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 50,795,976.54 (тавин сая долоон зуун ерэн таван мянга есөн зуун далан зургаан төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 46,663,624.40 (дөчин зургаан сая зургаан зуун жаран гурван мянга зургаан зуун хорин дөрвөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, сэлбэгээр худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Жаргалсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Сэлбэгээр худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

D.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн
 140 дугаар тогтоолын хавсралт

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
АКТАЛЖ, СЭЛБЭГЭР ХУДАЛДАХ ХӨРӨНГӨЙИН ЖАГСААЛТ

Д/ц	Автомашинны марк	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэлбэгээр худалдах доод үнэ (төгрөг)
1	Бульдозер Т-170	1991.01.01	50,795,976.54	46,663,624.40	4,132,352.14	4,500,000.00
			50,795,976.54	46,663,624.40	4,132,352.14	4,500,000.00

Нийт дүн	(тавин сая доллоон зуун өрэн таван мянга есөн зуун далан зургаан төгрөг тавин дөрвөн мөнгө)	(дөчин зургаан сая зургаан зуун жаран гурван мянга зургаан зуун хорин дөрвөн төгрөг дечин мөнгө)	(дөчин зургаан нэг зуун гучин хоёр мянга гурван зуун тавин хоёр төгрөг арван дөрвөн мөнгө)	(дөрвөн сая нэг зуун гучин хоёр мянга гурван зуун таван зуун мянган)
-----------------	---	--	--	--